



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 03 өдөр

Дугаар А/658

Булган сум

Гэрээ шууд байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Иргэний хуулийн 31, 32 дугаар бүлэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны XXV/05 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.1-ийн хэрэгжилтийг хангах арга хэмжээний хүрээнд суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцийг бүрдүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг ажлын байранд үе шаттай хөгжүүлэх сургалт, үйл ажиллагааг “Багшлахуйн баясгалан” НҮТББ-тай хууль, журмын хүрээнд 19,984,800 (арван есөн сая есөн зуун наян дөрвөн мянга найман зуун) төгрөгийн гэрээ байгуулж, хамтран зохион байгуулж ажиллахыг Боловсролын газар (Б.Мөнхгэрэл)-т үүрэг болгосугай.

2.Дээрх арга хэмжээний санхүүжилтийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ

